

**Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга
ХЭМЖЭЭ**

**ЭРХ ХАСАХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ХЭРЭГЖИЛТИЙН АСУУДАЛ**

**LEGAL REGULATION OF DISQUALIFICATION SENTENCES,
PROBLEMS OF IMPLEMENTATION**



Б.Дашдорж

Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахмад

Товч утга: Аливаа судалгааны ажил нийгэмд тулгамдаж буй тодорхой асуудлыг судалж шийдвэрлэхийг зорьдог. Энэхүү илтгэлээр эрх хасах ялын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь практикт тулгамдаж буй асуудлыг илрүүлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, шийдвэрлэх арга замыг дэвшүүлсэн болно.

Abstract: Any research work aims to investigate and solve specific problems facing society. In this report, the practical problems of the execution of the sentence of deprivation of rights are revealed, and the ways to improve and solve the legal regulations are proposed.

Түлхүүр үгс: Эрх хасах ялын шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн өнөөгийн байдал.

Keywords: The current state of legal regulation and implementation of disqualification sentence execution.

Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, хүний эрх, эрх чөлөө хангах ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрт ёсны болон үндэсний уламжлал, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, нийгэм, улс төр, эрх зүйн хүрээнд хууль тогтоомжийг чанд сахиулах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох нь төрийн үндсэн чиглэл юм⁵².

⁵² С.Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол./ялын тухай сургааль/ боть 2014.УБ хот 164,165

Төрийн бодлогын нэг хэсэг нь эрүүгийн хариуцлагыг оновчтой оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах үндсэн үүрэг байдаг⁵³.

Өнөөгийн нийгмийн хөгжлийн чиг хандлага, ард иргэдийн сэтгэлгээний өөрчлөлт, нийгэм эдийн засгийн үр нөлөө, эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх боломж нөхцөл зэргийг харгалзан хорихоос өөр төрлийн ялыг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрсөн байна.

Иймд хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох эрх хасах ялын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлын талаар 2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг харьцуулан судалж, практик, жишээн дээр тулгуурлан энэхүү илтгэлийг бичсэн болно.

Нэг. Эрх хасах ялын тухай ойлголт, түүхэн уламжлал

Эрт дээр үеэс Монголчууд гэмт хэрэг үйлдсэн хүнийг шоронд хорихоос илүүтэйгээр гэдэнд хийсэн хэргийг нь ойлгуулж, ухамсарлуулах ялын бодлого барьж байсан байна. Тухайлбал 1929 оны Шүүх цааз нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн ялын төрөл зүйлийн үндэс суурийг тодорхойлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт зан үйлийг засан сайжруулах зарчмыг тодорхойлсон чухал хууль цааз байжээ⁵⁴.

1934 онд Шүүх цаазын бичиг, 1942 онд Эрүүгийн хууль, 1961 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж, батлан дагаж мөрдөж байсан ба энэ үеийн эрүүгийн хууль тогтоомж дахь ял, түүнийг эдлүүлэх хэлбэрийг өмнөх хуулиудаас илүү боловсронгуй болгон хуульчилж өгсөн.

2002 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуульд эрх хасах ялыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд 1-5 жил хүртэл хугацаагаар үндсэн ба нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулахаар заасан бол 2015 оны эрүүгийн хуульд шүүх оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болохоор энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулахаар заасан.

Эрх хасах ялын цэрлэл нь ялтны эзэмшсэн ажил мэргэжлээрээ чөлөөтэй ажиллах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах эрхийг хязгаарлаж байгаагаар илэрнэ.

Эрх хасах ялын зорилго нь эрүүгийн хариуцлагын зорилготой агуулга нь ижилхэн боловч үйл ажиллагаа эрхлэх эрхийг хассанаар тухай гэмт хэргийг үргэлжлүүлэн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор уршгийг бууруулах, албаны эрх нөлөө, тусгай мэдлэгээ хууль тогтоомжийн хүрээнд ашиглаж хэвших хандлага төлөвшүүлэх зорилго агуулдгаар онцлог ялын төрөл гэж Эрх хасах ялын онцлогийг доктор /Ph.D/, профессор Г.Гантөмөр тодорхойлсон байна.

Эрүүгийн хууль тогтоомжийн ялын төрөл нь нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх зорилго чиглэлтэй шинэлэг ялын төрөл болохыг тодорхойлж гаргаж ирсэн бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засан сайжруулах шинжтэй байсан байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн

⁵³ Б.Нямгомбо. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэгдэх гарын авлага 2013. УБ

⁵⁴ С.Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол./ялын тухай сургааль/ боть 2014.УБ хот 164,165

төрийн албанд албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг 1-5 жил хязгаарлахаар зохицуулсан бөгөөд хэрэгжилтийг хэрхэн хангахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ухай хуулийн 99-100 дугаар зүйлд зааж өгсөн.

2015 оны Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 7 дах хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг 1-8 жил хүртэл хугацаагаар хориглохыг эрх хасах ял гэнэ⁵. Мөн хэрэгжилтийг хэрхэн хангахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 177-184 дугаар зүйл хүртэл зааж өгсөн.

Хоёр. Эрх хасах ялын шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн өнөөгийн байдал

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 99 дүгээр зүйлд Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх:

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол үндсэн ялыг эдэлж дууссан өдрөөс эхлэн, харин уг ялыг үндсэн ялын чанартай оногдуулсан.

Түүнчлэн албадан ажил хийлгэх, торгох ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоногийн дотор уг шийдвэрийн хувийг **ШҮҮХ** тухайн этгээдийг ажил, албан тушаалд томилсон, сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон төрийн захиргааны болон бусад байгууллагад хүргүүлж, ялтны оршин суугаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

100 дугаар зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага

100.1.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлээгүй этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 177.1. **Шийдвэр гүйцэтгэгч** эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэснээс хойш 5 хоногийн дотор ялтныг төрийн албанд томилсон, сонгосон, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах болон шүүхээс хориглолт, хязгаарлалт тогтоосон бусад эрх, зөвшөөрлийг олгосон байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

184 дүгээр зүйл. Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн ялтан, хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага¹¹

184.1.Ялтан эрх хасах ялаас зайлсхийсэн, эсхүл шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн бол **Зөрчлийн** тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Гэж зохицуулсан нь тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ял шийтгүүлсэн ялтан нь Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7.1 зааснаар хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 200.000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ хүлээх боломжтой байна.

Иймд хорих ялыг нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүйг дэлхий нийт хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас нь шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийг нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримталж ялтан этгээдийн

эдийн засаг санхүүгийн хэлбэрээр хариуцлага оногдуулж байна гэж үзэж болохоор байна.

Гадаад зарим оронд хорихоос өөр төрлийн маш олон янзын төрөл хэлбэрээр зохицуулсан байна. Тухайлбал: гэрийн хорионд байлгах, эд хөрөнгө хураах, нийтэд тустай ажил хийлгэх, түр хугацаагаар албадан эмчлэх, тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах, цол, одон медаль хураах, нутаг заах, сонгох, сонгогдох эрх хасах, бусад оронд зорчих эрхийг хязгаарлах, ан агнах эрхийг хасах, эдийн засгийн эрхийг хязгаарлах¹² гэх мэт маш олон төрлийн ялыг оногдуулж байна.

Манай орны эрх зүйн зохицуулалтаар эрх хасах ялыг хорихоос өөр төрлийн ялд хамруулж байгаа боловч түүнийг хэрэгжүүлэхэд хүлээлгэх хариуцлага арга хэлбэр нь тодорхой бус ялын үр нөлөө төдийлөн ялгарч харагдахгүй өдийг хүрсэн.

2017-2021 оны сүүлийн 5 жилийн судалгаагаар эрх хасах ялаар шийтгүүлсэн 2017 онд 916, 2018 онд 1268, 2019 онд 1495, 2020 онд 1743, 2021 онд 1850 ялтны ялын биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Судалгаанаас харахад эрх хасах ял шийтгүүлсэн нийт 5422 ялтнаас хорих ялаар сольсон тохиолдол байхгүй байгаа нь хууль эрх зүйн орчноор, хүлээлгэх хариуцлага муу байгаатай холбоотой гэж үзэж байна.

Дүгнэлт

Дэлхий нийтээр хорих ялыг нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүйг хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас нь шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийг нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримталж ялтан этгээдийн эдийн засаг санхүүгийн хэлбэрээр хариуцлага оногдуулж байна гэж үзэж болохоор байна.

Үүний нэг жишээ нь дээрх судалгаанаас харахад эрх хасах ял шийтгүүлсэн нийт 5422 ялтнаас сүүлийн 3 жилд хорих ялаар сольсон тохиолдол байхгүй байгаа нь хууль эрх зүйн орчноор, хүлээлгэх хариуцлага дутмаг, эрх хасах ялтанд торгох шийтгэл оногдуулж байхаар зохицуулсан гэж үзэж болохоор байна.

Санал

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан эрх хасах нэмэгдэл ялыг үндсэн ялд оруулж, хүлээлгэх хариуцлагыг нь нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг хуульд оруулах замаар боловсронгуй болгох шаардлагатай байна.

1. Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг санаатайгаар биелүүлээгүй этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх
2. Авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон этгээдийг улс төрийн албан тушаал эрхлэх эрхийг давхар хасах
3. Эрх хасах ялыг Эрүүгийн хуульд үндсэн ялын шинжтэй оногдуулж болохоор хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг саналыг дэвшүүлж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. С.Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол./ялын тухай сургааль/ боть 2014.УБ хот
2. Б.Нямгомбо. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэгдэх гарын авлага 2013. УБ
3. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2020 он
4. Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. Сурах бичиг 2020 он
5. Эрүүгийн хууль 2015 оны төрийн мэдээлэл сэтгүүл
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 оны төрийн мэдээлэл сэтгүүл
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он,№41
8. Зөрчлийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он,№41
9. Google сайт <https://en.wikipedia.org/>
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нэгдсэн тоо бүртгэлийн хэлтсийн тайлан 2020 он

---o0o---